



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.30 № 714

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ  
СҮМҮН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ БАТШИРЭЭТ СҮМҮН  
МАН-ЫН ХОРООНЫ ДАРГА  
Г.ГАНСҮХ ТАНАА

- Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд <sup>7</sup>  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хэнтий аймгийн Батширээт сумын МАН-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн

2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Хэнтий аймгийн Батширээт сумын МАН-ын хорооны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хэнтий аймгийн Батширээт сумын МАН-ын хорооны мөрийн хөтөлбөр (9 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн Батширээт сумын Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Д.ОЮУНТУЯА

Д.ЭРДЭНЭБИЛЭГ

Ц.ХАТАНБОЛД



БАТШИРЭЭТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА.

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХУРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Орон сууц
- 1.2. Эрүүл мэнд
- 1.3. Боловсрол
- 1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт
- 1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт
- 1.6. Хүүхэд гэр бүлийн хөгжил

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Хөдөө аж ахуй
- 2.2. Аялал жуулчлал
- 2.3. Дэд бүтцийн сүлжээ
  - 2.3.1. Эрчим хүчний төсөл
  - 2.3.2. Агаарын тээвэр
  - 2.3.3. Авто зам



ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО



## НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 1.1. Орон сууц

1.1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдийг орон сууцжуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ хамтран ажиллана.

1.1.2. Орон сууцны төлөвлөлтэд ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ

1.1.3. Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд эзлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээл олгох ажлыг боломжийг судлан хэрэгжүүлнэ.

1.1.4. Зорилтот бүлэг /төрийн албан хаагч, залуу гэр бүл/-д чиглэсэн орон сууцны төслийг хэрэгжүүлж, урьдчилгаа төлбөрийн батлан даалт, ипотекийн зээлийн асуудлыг шийдвэрлэх.

### 1.2. Эрүүл мэнд

1.2.1 Орон нутагт дутагдалтай байгаа змч, мэргэжилтнийг бэлтгэх бодлогыг тодорхойлж, тэднийг чадавжуулах, хүний неөцийн нийгмийн баталгааг ханган ажиллана

1.2.2. Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэгийг тасралтгүй үргэлжлүүлж, дундаж наслалтын хүйсийн ялгаатай байдлыг багасгах бодлого хэрэгжүүлнэ.

1.2.3. Өвчнөес урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд сууринсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлгийг нэмэгдүүлнэ.

1.2.4. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөес урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.5. Монгол улсын хэмжээнд 3000 змч, 10000 сувилагч, 500 мэргэшсэн асрахуйн ажилтан гадаад, дотоодод бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүний неөцийг чадавжуулах арга хэмжээг чиглэл бүрээр зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна.



1.2.6. "Элэг бүтэн Монгол", хүүхдийн "Эрүүл шүд", "Умайн хүзүүн хавдаргүй Монгол" хөтөлбөрүүдийг орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.7. Эрүүл мэндийн төвийн ажилчидын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд эмчийн байрыг шинээр барьж ашиглалтанд оруулна.

1.2.8. Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

### 1.3. Боловсрол

1.3.1. Сумын 2013 онд ашиглалтад орсон сургуулийн барилгад их засварыг хийнз.

1.3.2. Ерөнхий боловсролын сургуулийн хүний нөөцийг бүрдүүлэх, дутагдалтай мэргэжлээр суралцаж буй оюутан залуусыг орон нутагт ажиллах боломжуудыг сурталчилах өдөрлөгүүдийг зохион байгуулна.

1.3.3. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.

1.3.4. Бага, дунд боловсролын чанарыг дээшшуулж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн-терөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хүүхдийг хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.

2317144297  
СЮА0046 9074082

1.3.5. Нүүдлийн соёлын чадавхыг ерөнхий боловсролын сургалтаар өгөх, бэхжүүлэх хүрээнд биеийн тамирын хичээлийн агуулгад үндэсний бөх, технологийн хичээлд хатгамал, дээл оёх, хөгжмийн хичээлд уртын дуу, морин хуур, биөлгээг оруулна.

1.3.6. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.3.7. ЕБС-д байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбайг тохижуулна.

1.3.8. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлнэ.

1.3.9. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нэхцэлийг сайжруулж зориулалтын тоног төхөөрөмжкеөр хангана.



1.3.10. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн гэрэлтүүлэх, камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.3.11. Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, хүүхдэд эзлтэй орчин бүрдүүлнэ.

1.3.12. Төспөөр баригдсан гадна бэлтгэл бүлгийн барилгад их засвар хийнэ

1.3.13. Монгол бичгийн үндэсний хетэлбөр 3-ийг хэрэгжүүлнэ

#### 1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт

1.4.1. Иргэдийг хөдөлмерийн зах зээл дэх эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлээр мэргэжлийн сургалтад хамруулан бүтээмжтэй, зохистой ажлын байрыг бий болгох замаар, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмер эрхлэлтийг нэмэгдүүлж ажилтай, орлоготой болгож, ядуурлын түвшинг бууруулна.

1.4.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулж, оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг дэмжих хөгжүүлнэ.

1.4.3. Ахмадын аймгийн аварга шалгаруулах спортын тэмцээнд оролцох ахмадууд дэмжлэг үзүүлэн ажиллана.

1.4.4. Төрийн байгууллагуудын нэрэмжит Ахмадын өдөрлөгийг уламжлал болгон явуулна.  
СЮА0046 9074082

1.4.5. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвийг засварлаж үйл ажиллагааг тогтмолжуулна

1.4.6. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлсэн тохируулгатай ажлын байр бий болгосон жишиг байгууллага, аж ахуйн нэгжийг жил бүр шалгаруулан урамшуулна.

1.4.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.4.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.



1.4.9. Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ

### 1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт

1.5.1. Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалтыг сайжруулна.

1.5.2. Үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, здийн засгийн эргэлтэд оруулна

1.5.3. Сумын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж тоног төхөөрөмжөөр хангана.

1.5.4. Нутгийн бахархал болсон зохиолч яруу найрагчдыг алдаршуулж Н.Нямдоржийн нэрэмжит "Онон хатан Ижий" яруу найргийн наадмыг 3 жил тутамд зохион байгуулна.

1.5.5. Ардын урлагийн ёОХОР наадмын 2 жил тутамд зохион байгуулна.

1.5.6. Шинэ сумын Музейн үйл ажиллагааг идэвхжүүлж, үзмэрийг шинээр дэглэнэ.

1.5.7. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, хөдөлгөөнт дасгал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ. СЮА0046 9074082

1.5.8. Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын аймаг, бус, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

1.5.9. Спорт заалыг тохижуулж үйл ажиллагааг сайжруулна.

### 1.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжил

1.6.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх сумын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.6.2. Хүүхэд гэр бүлд үзүүлэх хөгжлийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн, нийт хүүхэд гэр бүлийн 50 хувьд үйлчилгээ үзүүлнэ.

1.6.3. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.



1.6.4. Сумын төв болон багуудад стандарт нийцсэн хүүхдийн тоглоомын талбайг байгуулна.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### 2.1. Хөдөө аж ахуй

2.1.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлэх.

2.1.2. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, "Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.3. Усалгаатай газар тариаланг хөгжүүлэн төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн хэрэгцээг бүрэн хангаж сумандаа бүрэн нийлүүлнэ.

2.1.4. Мал нядлагааны цэгтэй болно.

2.1.5. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг сумын хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.

2.1.6. Малчид хоршоолох замаар мах, сүү, арас шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.1.7. Малчид залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

2.1.8. Мал амьтнаас хүнд халдвартадаг халдварт өвчний хяналт, сэргийлэлт, яаралтай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахажлын хүрзэнд бага оврын лабраторыг байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.1.9. Малын үүлдэр угсааг сайжруулах эцэг мал /Хуц,ухна, бух/-ыг худалдан авч иргэдэд гэрээгээр эзэмшүүлнэ.

### 2.2. Аялал жуулчлал

2.2.1. "Гурван гол" байгалийн хүрээлэнг тохижуулж аялал жуулчиллыг хөгжүүлнэ.

2.2.2. Аялал жуулчлалын гол маршрут дагуух отоглох цэгийг бий болгоно.

2.2.3. Аялал жуулчлалын ач холбогдол бүхий газруудыг google тар дээр байршуулах мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

2.2.4. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, чадавхижуулах, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.



2.2.5. Барх гол, Онон гол дагсан өрхийн аялал жуулчлалыг дэмжиж шовгор, гэр кэмпийг хөгжүүлнэ.

### 2.3. Дэд бүтцийн сүлжээ

#### 2.3.1. Эрчим хүчний төсөл

2.3.1.1. Багануур–Чингис–Чойбалсан 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам баригдсанаар сумын эрчим хүчний тасалдлыг арилгана.

2.3.1.2. Нарлаг хороолол, Сүүл толгойн шинэ суурьшлын бүсэд цахилгаан дамжуулах шугам татах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, суурьшлын бүсийг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.3.1.3. Сумын төвийн Цамхаг болон гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.

#### 2.3.2. Агаарын тээвэр

2.3.2.1.Далын тасагт байрлах туршилтын нисэх буудлын талбайг тохижуулах, хамгаална.

#### 2.3.3. Автозам

2.3.3.1. Өмнөдэлгэр sumaас Батширээт, Биндэр, чиглэлийн хатуу хүчилттай авто замыг барьж ашиглалтад оруулснаар аялал жуулчлалыг <sup>0313144005</sup> сум руу татан хөгжүүлнэ.  
СНОА0046 9074082

2.3.3.2. Сумын төв доторх авто замыг хатуу хүчилттай болгох зургийг хийлгэж үе шаттай хэрэгжүүлнэ.

2.3.3.3. Онон голын төмөр бетон гүүрийн зүүн талын замыг засварлаж аюулгүй зорчих боломжийг бий болгоно.

2.3.3.4. Бархын төмөр бетон гүүрийн урд талын жижиг гүүрийг холбосон замыг засварлана.

2.3.3.5. Сумын төвийн хотгор гүдгэртэй гудмын замыг засварлах зураг, төсөв хийлгэж засварлана.

### ГУРАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Хог хаягдал ангилан ялгаж, боловсруулах боломжийг судлан хэрэгжүүлнэ.

3.2. Жил бүр 100-200 мянган мод тарих замаар ойн сан, хамгаалалтын ойн зурvasыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангана.



- 3.3. Сумын Зга цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж тохижуулна.
- 3.4. Жил бүр 2000-5000 га талбайд ойн хенеелт шавьжтай тэмцэнэ.
- 3.5. 10 га Мод үргүүлгийн паркыг тохижуулж Иргэд, ААН, Байгууллага, Нөхөрлөлүүдийг ногоон эдийн засгийг бий болгож өрхийн орлог нэмэгдүүлнэ.

### **ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

- 4.1. Суманд Гал түймэр унтраах булэг байгуулж техник хэрэгсэлийг нэмэгдүүлнэ.
- 4.2. Зайлшгүй шаардлагатай асуудлаар хяналт шалгалт хийх "НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ"-ыг тогтмол зохион байгуулж иргэдийн мэдэх эрхийг хангана.
- 4.3. Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 4.4. Багш, эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлзэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.
- 4.5. Төрийн түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, гурваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох бодлого баримтална.
- 4.6. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
- 4.7. Төндөр сонгон шалгаруулалт, газар олголт, орон нутгийн эд хөрөнгийн дуудлага худалдааг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх бүх боломжийг бий болгох, хариуцлагажуулна.
- 4.8. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах "Асуудлаас шийдэлд" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.9. Орон нутагт шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор "Зөгийн Үүр" арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.10. Орон нутгийн төсвээс санхүүждэг төрийн байгууллагад ажиллагсдад орон нутгийн нэмэгдлийг нэмэгдүүлэн олгоно.
- 4.11. Суманд камержуулалтын системийг бүрэн нэвтрүүлнэ.
- 4.12. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, иргэд, бизнест төвөггүй, хялбар үйлчилгээг үзүүлнэ.



## ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО.

- 5.1. Төсөвт байгууллага болон ААНЭГЖ дэлгүүрийг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- 5.2. Мөөгт шинэ суурьшлын бүсэд Цэвэр усны эх үүсвэрийн худаг шинээр гаргана.
- 5.3. Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усан хангамж, усан сангийн байгууламжийг суманд барьж байгуулна.
- 5.4. Үүрэн төлөфоныг сүлжээг өргөтгөнө.
- 5.5. Сумын Үерийн ус зайлцуулах зургийг хийж гүйцэтгэнэ.
- 5.6. Суманд Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийг барьж байгуулна.
- 5.7. Жишиг гудамж төслийг сумын төвд үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна
- 5.8. Суурин газруудад байгаа хуучирч муудсан, эзэмшил нь тодорхойгүй, иргэд олон нийтийн аюулгүй амгалан байдалд сэргээр нөлөөлөхүйц барилга байгууламжийг тогтоон нэг мөр цэгцлэх, газрыг чөлөөлүүлэх, буулгах, шинээр бүтээн босгож эдийн засаг, нийгмийн зргэлтэд оруулна
- 5.9. Сумын Зүүн талын үйлдвэрийн цэвэр усны худгийг ухаалаг системд үе шаттайгаар шилжүүлнэ.
- 5.10. Төрийн байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хамгаалалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох арга хэмжээ, хариуцлага тооцож ажиллана.

